

БНХАУ-ЫН НИЙГМИЙН ШИНЭТГЭЛ*Н.Ариунгуа**

Хятад улс өөрчлөлт шинэчлэлийн бодлогоо нийгмийн баримжаатай хэрэгжүүлэх зорилт тавьсан билээ. Гэвч энэхүү зорилтыг хэрэгжүүлэх явцад Хятад улс багагүй амжилт олсон боловч шийдвэрлэгдээгүй олон асуудал Хятадын нийгмийн өмнө тулгарсан хэвээр байгааг бид дээр тэмдэглэсэн билээ. Хятадын нийгэмд тулгарч буй асуудлуудыг дотоод гадаадын шинжээч эрдэмтэд тун ойролцоо тодорхойлж байгаа бөгөөд 2005 онд Хятадын эрдэмтэд нийгмийн тулгамдсан асуудлуудын дундаас доорхи зүйлүүдийг онцолж байна. Үүнд: 1. 40 сая гаруй тариачдын газрыг хураан авч өөр зорилгоор ашиглах болж нөхөн олговорыг бага хэмжээгээр тогтоосноор үүдэн гарсан зөрчил. 2. Хүн амын орлогын ялгаа эрс нэмэгдэж байгаа 3. Урт удаан хугацаанд ажилгүйдэл буурахгүй улам нэмэгдэж байгаа / жил бүр ажилгүйчүүдийн тоо 24 сая хүнээр нэмэгдэж байхад Хятад улс жил бүр зөвхөн 9 сая хүний ажлын байр бий болгох бололцоотой/ 4. Ядуурлыг бууруулах зайлшгүй шаардлага /НҮБ-ын зүгээс ядуурлын заагийг жилийн орлого 900 юаниар тогтоосон байхад Хятадын тариачдын жилийн дундаж орлого зөвхөн 625 юань байдаг байна/. 5.Авилга хээл хахуультай үр дүнтэй тэмцэхийн тулд улс төрийн шинэтгэлийг хийх зайлшгүй шаардлага. 6. Цаашдын хөгжлийг хязгаарлах байгалийн нөөцийн хомсдол ба орчин тойрны бохирдол. 7. Бага орлоготой хүмүүсийн бухимдал нэмэгдэж байгаа /эдийн засгийн өсөлт хурдцыг эс харгалзан/.¹

Дээр дурьдсан зүйлүүд нь Хятадын нийгэмд тулгарч буй хурц асуудлуудыг тоймлон гаргасан зүйл бөгөөд Хятадын шинэчлэлийн бодлогыг нийлэнхүйд нь тодорхойлох үзүүлэлт биш гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу. Учир нь Хятад улс өөрийгөө хөгжлийнхөө шинэ шатанд гарч чинээлэг нийгмийг байгуулах, социалист шинэчлэлийг түргэгсэх үе шатандаа гарч ирсэн хэмээн тодорхойлж, шинэчлэлийн үр дүнд нийт улсын хүчин чадал эрс нэмэгдэж, хүн ардад дээд зэргийн ашиг олгосон, нийгмийн тогтвортой байдал болон ард иргэдийн нэгдлийг хангасан үе гэж ерөнхийд нь тодорхойлж байна.²

Хятадын эдийн засгийн хөгжлийн үр дүн хүн амын аж байдал, нийгмийн хөгжилд хэрхэн тусч байгааг доорхи үзүүлэлтээс харж болно. Тухайлбал 2003 оны байдлаар хүн амын амьжиргааны түвшинд ахиц гарсан бөгөөд 1997-2002 оны байдлаар хотын хүн амын дундаж орлогын өсөлт 8,6%, хөдөө тосгоных 3,8%, хот суурин, хөдөө тосгоны хүн ардын хуримтлал 2 дахин нэмэгджээ. Ядуучуудын тоо хөдөө 21,4 сая хүнээр

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

багассан, хүн ардын худалдан авах чадвар нэмэгдсэн, өргөн хэрэглээний барааны гүйлгээ 10,5% тус тус нэмэгдсэн, хотын хүн амд ноогдох орон сууцны талбай 17,8 м² байснаа 22 м² хүртэл, хөдөө тосгоных 22,5 м²-аас 26,5 м² хүртэл нэмэгджээ. Хүн ардын эрүүл мэндийг хамгаалах, эмчилгээ, сувилалын үйлчилгээ тууштай дээшлэн сайжирч дундаж наслалт 71,8 нас хүрч хөгжилтэй орнуудын түвшинд ойртож очжээ.³ Ийнхүү Хятад улс багагүй амжилтанд хүрсэн боловч шийдвэрлэгдээгүй олон асуудал Хятадын нийгмийн өмнө тулгарсан хэвээр байгаа юм. Үүнийг Хятад улсын удирдлага ХКН-ын ХҮИ их хурал /2002.10 сар/ дээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд хүн амын чинээлэг амьдралын түвшин жигд бус хийгээд амьдралын бүхий л талыг хамарч чадахгүй байгаа, хүн ардын байнга өсч буй материаллаг болон соёлын хэрэгцээ нийгмийн хоцрогдсон үйлдвэрийн аргатай зөрчилдөж байгаа, шинжлэх ухаан, техник, боловсролын түвшин харьцангуй хоцрогдсон, аж үйлдвэржүүлэлт, шинэчлэлт урт удаан хугацааны үйл явц учир бүс нутгийн хөгжлийн ялгааг арилгахад цаг хугацаа шаардагдаж байгаа, хүн ардын дунд ядуус багагүй байгаа зэргийг дурьдсан байна. Ийнхүү төлөвлөгөөт эдийн засгаас холимог эдийн засагт шилжих үйл явц жигд явагдаагүй, явцын дунд тулгарч буй бэрхшээлийг Хятадын засгийн газар макро түвшинд засч залруулахаа удаа дараа мэдэгдсээр байгаа юм. Тухайлбал ХКН-ын бүгд хурал /2005.3/, БХАТИХ-ын ээлжит чуулганууд /2005, 2006/ дээр эдийн засаг-нийгмийн хөгжлийн явцад гарч буй бэрхшээл, алдаа завхарлыг макро түвшинд засч залруулах талаар удаа дараа шийдвэр гаргасан бөгөөд эдийн засаг, нийгмийн салбарыг “өв тэгш” хөгжүүлэх, юуны түрүүнд “хүнийг дээдлэх” бодлогын ач холбогдлыг заасан. Иймээс хөдөлмөрийн, ялангуяа амьжиргааны түвшин доогуур хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг онцгойлон авч үзэх болсон юм. Улмаар хот хөдөөгийн нэн ядуу хэсэгт бодит туслалцаа үзүүлэх тухайлбал эмнэлгийн тусламж, хүүхдийн сургалт, орон гэр, өвлийн халаалт зэрэгт туслах мөн ядуу, бага дунд орлоготой хүмүүсийн худалдан авах чадварыг нэмэгдүүлснээр улс ардын аж ахуйн хөгжлийг түргэсгэхийн ач холбогдлыг заажээ.⁴

Хятадын засгийн газар хотын хүн амын амьжиргааны доод түвшинг дээшлүүлэх зорилгоор 2002 онд 4.6 тэрбум юаний дотаци гаргасан бол дараа жил нь 9.2 тэрбум юань хүртэл өсгөсөн байх бөгөөд 22.35 сая хүний амьжиргааны доод түвшинг дээшлүүлсэн байна. Тэтгэвэр, ажлын хагас өдөр ажиллагсдад зориулж төвийн санхүүжилтээс гаргах дотацийг 13%-иар нэмэгдүүлжээ. Мөн хүн амыг ажлын байраар хангах асуудалд анхаарал хандуулсаар ирсэн бөгөөд төвийн санхүүжилтаас 2003 онд 4,7 тэрбум юань нэмж гаргасан бол 2004 онд хотын хүн амын 9 сая хүнийг ажлын байраар, 5 сая хүнийг хагас ажлын байраар хангасан байна. 2006 онд 9 сая хүнийг ажлын байраар хангаж, ажилгүйдлийг 4.6%-д барих

зорилт тавьжээ.⁵ Нөгөөтэйгүүр санхүү зээлийн дэмжлэгийн бодлогыг тухайлбал татварыг хөнгөвчлөх буюу татвараас чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд мал аж ахуйгаас татвар авахаа байжээ.

Хятад улс зах зээлийн эдийн засагт шилжснээр Хятадын нийгмийн бүхий л анги давхрагыг хөндсөн бөгөөд энэ нь юуны түрүүнд ажилчин, тариачдын амьдралд асар их нөлөө үзүүлсэн юм. Аж үйлдвэрийн салбарт техник технологийн шинэчлэл хийгээд хувьчлал явагдсны үр дүнд олон хүн ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж, Хятадын нийгэмд маргинал хүн амын давхаргыг улам нэмэгдүүлсэн байна. Хэдий Хятадын засгийн газраас цомхотголоор буюу үйлдвэр аж ахуйн газар хаагдсаны улмаас ажилгүй болсон хүмүүст тодорхой хугацаанд тэтгэлэг олгох дахин сургалтанд хамруулах ажил зохиосон боловч төр энэ их ачааллыг нуруун дээрээ үүрэх бололцоогүй ажээ. Үүний улмаас олон мянган хүн мэргэжлээ солин үйлчилгээний салбарт шилжих буюу гудамжинд гарч байна. Хэдий ажилчин анги ХКН-ын ангийн болон нийгмийн бааз хэвээр байгаа гэж үзэж түүний онцгой эрхийг хамгаалахын чухлыг зааж байгаа боловч зах зээлийн эдийн засгийн үед ажилчин ангийн статус буурсан бөгөөд энэ байдалд Хятадын ажилчин анги сэтгэл дундуур байгаа ажээ. Ажилчин ангийн нийгмийн статусыг нэмэгдүүлэх гол арга бол шинэ техник, технологи эзэмших улмаар орлогоо нэмэгдүүлэх явдал юм гэж хятадын шинжээчид үзэж байгаа⁶ боловч энэ нь бидний дээр дурьдсанчлан ажилчин ангийн эгнээг багасгаж маргинал анги давхаргыг нэмэгдүүлэх үзэгдлийг бий болгох юм.

Хятадын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл нь хөдөө аж ахуйн салбарт дөнгөж эхлэлийн төдий байгаа бөгөөд цаашид улам гүнзгийрэх чиглэлтэй байна. Судлаачдын үзэж байгаагаар хөдөө аж ахуйн салбар дахь шинэчлэл нь Хятадын нийгмийн байдалд багагүй бэрхшээл авчрах бөгөөд түүний амжилтаас Хятадын шинэчлэлийн хувь заяа шийдэгдэх ажээ. Хөдөө аж ахуй дахь техник-технологийн шинэтгэл нь тариачдын гар ажилбар бүхий ажил эрхлэлтэнд шууд нөлөөлж үүнээс улбаатайгаар олон тооны тариачид ажилгүйчүүдийн эгнээнд орох юм. Гэтэл өнөөгийн байдлаар Хятад дахь 74 сая ажилгүйчүүдийн ихэнхи хувь нь хөдөө тосгонд ноогдож байгаа юм. Ер нь Хятадын хөдөө аж ахуйн салбар бол эдийн засгийн хамгийн хоцрогдсон салбар учир хятадын хөдөө тосгонд нийгмийн талын маш их шийдвэрлэгдээгүй асуудлууд амь бөхтэй оршсоор байна. Иймээс Хятадын засгийн газраас хөдөө тосгоны хөгжил, тариачдын амжиргааг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа юм. Тухайлбал 2005 оны 1-р сарын 30-нд ХКН-ын Төв хорооны баримт бичиг №1 болох “Хятадын засгийн газраас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай бодлогын зарим нэгэн үзэл санаа” гэсэн баримт бичиг гарсан бөгөөд энэхүү баримт бичигт хөдөө аж ахуй дахь бодлогыг эрчимжүүлэн тууштай хэрэгжүүлэх үүднээс хөдөө аж ахуйн салбар, хөдөө

тосгоны эдийн засгийн бүтцийг зохицуулах, шинэчлэлийг гүнзгийрүүлэх зэргээр хөдөөгийн хөдөлмөрчдийн ажлын ачааллыг багасгах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг оновчтой зохицуулах, үндсэн үнийг тогтвортой байлгах, эрэлт хэрэгцээ нийлүүлэлтийн тэнцвэрийг хадгалах, тариачдын тоог багасгах, аажмаар хөдөө аж ахуй дахь менежментийг сайжруулан, тариачдын орлогыг тогтвортой нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбар, хөдөө тосгон руу санхүүжилтийг ахиу хуваарилах, татварыг хөнгөлөх, татвараас чөлөөлөх, дотаци олгох замаар дарамтыг багасгах мөн нийгмийн талын үйлчилгээг үзүүлэх зэргийг заажээ.

Хятадын засгийн газраас баруун бүс нутгийн зарим ядуу муж тосгонд их хэмжээний тусламж үзүүлэх ажээ. Өнөөгийн байдлаар татварын хөнгөлөлт үзүүлэх 25 муж, өөртөө засах орон, төвд харъяалагдах хотууд байгаа ажээ. 80-аад оноос эхлэн хөдөө тосгоноос хот суурин газар руу маш олон тооны тариачид шилжин суурьшиж байгаа бөгөөд 1995 оны байдлаар л гэхэд 80 саяд хүрсэн байна. Энэхүү шилжих хөдөлгөөн нь залуу, дунд насны ажлын хүчийг эрс багасгасан байна. Хот суурин газар шилжин ирсэн тариачид шилжилтийн бүртгэл байхгүй учир нууцаар ажил эрхэлдэг бөгөөд хэрэв баригдвал тэднийг оршин суух хаягаар нь буцаадаг ажээ. Тэдний ихэнх нь Шанхай зэрэг том хотуудад барилга дээр 18 цаг ажиллаж сарын 150 ам.долларын хөлс авдаг байна.

Хөдөө тосгон дахь өөрчлөлт шинэчлэл нь гэр бүлийн бүтэц, түүний үүрэг, гэр бүлийн харьцаанд маш их өөрчлөлтийг авчирсан байна. Одоо хөдөө тосгонд 1-2 хүүхэдтэй айл давамгайлах болсон бөгөөд гэр бүлийн гишүүд цөөрсөн явдал өрхийн үйдвэрлэлийн функцийг сулруулах хандлага ажиглагдаж байна. Олон тооны тариачид төрөлх тосгоноо орхин хот суурин газар бараадах болсон нь ар гэрт нь ихээхэн хүндрэл учруулж байгаа ба ажлын хүндийг эмэгтэйчүүд үүрэх болсон байна. Хөдөө тосгонд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлж байгаагаар амиа хорлох явдал эмэгтэйчүүдийн дунд их байгааг мөн дурьдаж байна. Яагаад хөдөө тосгонд залуу эмэгтэйчүүд сайн дураараа энэ хорвоог орхих болсон явдлыг судалж үзэн хэд хэдэн шалтгааныг илрүүлжээ. Тухайлбал хөдөө тосгон дахь эмэгтэйчүүдийн нийгмийн байдал маш доогуур, ядуурал их, гэр бүлийн харьцаа хэвийн биш, албан хүчээр нөхөрт гаргах явдал олширсон, гэр бүлийн хүчирхийлэл, гэрлэлтээ цуцлуулах боломжгүй, хүүхэд төрүүлэхийг хязгаарлаж байгаа, хүнд хүчир ажил, байнгын стресс, амиа хорлох явдлыг нийгмийн болон шашны талаас цээрлэдэггүй зэрэг юм. Ер нь Хятад улсад бусад орнуудтай харьцуулахад хөдөө тосгонд уг үзэгдэл хот газрынхаас элбэг тохиолддог ажээ. Амиа хорлогсдын 58% нь химийн бордоо ашигладаг байна. Бүх Хятадын эмэгтэйчүүдийн холбооноос мэдэгдэж байгаагаар Хятадад жил бүр 150 мянган эмэгтэй амиа хорлодог буюу

1,5 сая нь ийм оролдлого хийдэг байна.⁷ БНХАУ-ын Эрүүл мэндийн сайдын мэдэгдэж байгаагаар нийгмийн энэхүү үзэгдэл юуны өмнө өрсөлдөөн, ажилгүйдэлтэй холбоотой ажээ. Хот суурин газар ч энэ асуудал хурцаар тавигдаж байна. Үйлдвэр, аж ахуй газар татан буугдсаны улмаас үүссэн ажилгүйдлийн 60%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд 1996-2000 оны 9-р таван жилийн хугацаанд ажилгүй бологсдын 2/3 нь эмэгтэйчүүд ажээ. Хятадын нийгэмд байгаа энэхүү үзэгдэл нь судлаачдын үзэж байгаагаар нийгмийн шинэчлэлийн үйл явцын сөрөг үзүүлэлт бөгөөд нийгмийн гишүүд ерөнхийдөө чиглэлээ алдсан, хувь хүн хамт олны хоорондын холбоо тасарсан, гэр бүлийн бүтэц, үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой гэжээ. Урьд мөрдөгдөж байсан нийгмийн зохицуулалтын уламжлалт механизм алдагдсан, өрсөлдөөн ихэссэн, хүний хүсч санаж байсан зүйл нь бодит амьдрал дээр хэрэгжих боломжгүй болсон зэрэг нь сэтгэл санааны хямралд оруулдаг ажээ. Амьдралын хэв маяг, хурд өөрчлөгдсөн, шийдвэрлэх асуудлууд олширч, хэрэгжүүлэхэд улам хүнд бэрх болсон зэрэг нь сэтгэл санааны дарамтанд оруулж хүн бүр энэхүү хямралыг даван туулж чадахгүйтэй холбоотой байдаг байна. Иймээс Хятадын засгийн газраас энэхүү асуудлыг хүн ардын сэтгэл санааны байдлыг илтгэж буй ноцтой үзүүлэлт хэмээн үзэж 2003 онд амиа хорлох үзэгдэлтэй урьдчилан тэмцэх төрийн бодлого хэрэгжүүлж байгаа ажээ.

Ер нь Хятадын засгийн газраас нийгмийн асуудалд хэрхэн анхаарал хандуулж байгааг доорхи хүснэгтээс харж болох юм.

Хүснэгт 1

Статистик индекс	1985	1990	1995	2001
Хот суурин газрын хүн ам /10 мянга/	25094	30195	35174	48064
Шинээр баригдсан тохилог орон сууц 100 сая	1.88	1.73	3.95	5.75
Хувийн байшин	-	926.55	3344.81	18250.77
GDP /100 сая юань/	8989	18598	57495	94346
Гадаад хөрөнгө оруулалт /100 сая ам.долл/	44.6	102.9	481.3	496.7
Импорт, экспортын дүн /100 сая ам.долл/	696.0	1154.0	2808.6	5097.7
Эрчим хүчний хэрэглээ /10 мян.т.нүүрс/	76682	98703	131176	132000
Хот газар дахь ажилгүйдлийн хэмжээ	1.8	2.5	2.9	3.6
Үүрэн утас хэрэглэгчдийн тоо /10 мянга/	-	1.8	362.9	14522.2
Интернет ашиглагчдын тоо /10 мянга/	-	-	0,7	3656.2

Хятад улс нийгмийн хамгааллын талаар тавьж буй нэг асуудал бол настангууддаа үзүүлж буй халамж анхаарал юм. Тухайлбал настангуудын эрхийг хамгаалах БНХАУ-ын хууль хэрэгждэг бөгөөд настайчуудын тулгамдсан асуудлыг судлах судалгааны төв байдаг байна. Гэвч Хятад улсад настайчуудын нийгмийн хамгааллын асуудал хурц хэвээр байгаа бөгөөд энэ чиглэлээр төрөөс арга хэмжээ авч байгаа боловч тэр бүр үр дүнгээ өгөхгүй байгаа нь шинэчлэлийн бодлого бүрэн төгс хэрэгжиж амжаагүйтэй холбоотой болов уу. Ийнхүү настайчууд түүн дотроо хөдөө тосгоны нас дээр гарсан хүмүүсийн аж байдлыг сайжруулах явдал бол хятадын шинэчлэлийн тулгамдсан асуудлуудын нэг юм. Хятадын хөдөө тосгоны настайчуудын амьдрал ядуу дорой байдаг нь тэд хот суурин газрын настайчуудын адил улсаас тэтгэвэр авдаггүйтэй холбоотой юм. Тэдний амьжиргааны гол арга бол газар бөгөөд 60 дээш насны бараг бүх тариачид /ялангуяа эдийн засгийн хувьд хоцрогдсон баруун болон төвийн бүсийн/ өөрийн эзэмшил талбай дээрээ залуучуудтай мөр зэрэгцэн ажиллаж өөрийгөө тэжээж байна. Залуучууд хот суурин газар бараадах болсон нь настайчуудын нуруун дээр газар хагалах, ач гучаа харах хүнд ачаа ирдэг байна. Орон нутгийн зөвлөл нь настайчуудад эд материалын туслалцаа үзүүлдэггүй. Эдийн засгийн хувьд хөгжилтэй бүс нутгуудын хөдөө тосгонд хувийн үйлдвэрлэл хөгжсөн зэрэг нь тодорхой хэмжээгээр хамтын фонд байгуулах бололцоотой болсон боловч тэндээс хувь хүнд ноогдох мөнгөн тусламж наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа ажээ. Тухайлбал Жэянь мужийн нэгэн тосгонд хамтын фондоос сар бүр эрэгтэйчүүд нь 20 юань, эмэгтэйчүүд нь 15 юань авдаг байна.⁸ Хятадын нийгэмд хот хөдөө тосгоны настайчуудын амьжиргаа, нийгмийн хангамж ийнхүү ялгаатай байгаа нь Хятадын хот хөдөөг зааглаж байгаа асар гүнзгий хавцал байгааг харуулж байна хэмээн судлаачид үзэж байна. Энэхүү зааг ялгааг арилгахад маш их хугацаа шаардагдах бөгөөд хот хөдөөгийн ялгаа арилах явцад аажмаар багасах бололтой. Хөдөө тосгоноос хот суурин газар руу шилжих замаар энэхүү асуудлыг шийдэж болох боловч хөдөө тосгоноос хот руу шилжих үйл явц удаан жил үргэлжилж байгаа боловч хот газрын үйлдвэрийн газруудад ажиллаж буй хөдөөний хүмүүс хотынхонд үзүүлдэг нийгмийн халамж, дэмжлэгийг хүртэж чадаагүйгээс харахад энэ нь тийм ч оновчтой арга биш бололтой. Хятадын тосгоныг өөрийг нь шинэчлэх нь настайчуудыг нийгмийн халамжинд хамруулах чухал арга юм. Юуны өмнө тариачид газар эзэмших эрхээ үр хүүхдүүдээ шилжүүлэх эрхийг хуульчлах шаардлагатай мэт боловч энэ нь жижиг аж ахуйтнуудыг бэхжүүлэх муу талтай ажээ. Нөгөөтэйгүүр нэлээд хөгжилтэй бүс нутаг болох зүүн бүсийн хөдөө тосгоны жишээнээс

харахад хамтын хуримтлал маш доогуур хэмжээнд байгаа нь энэхүү асуудлыг үндсээр нь өөрчилж чадахгүй бололтой.

Улс орны хөгжлийн амжилт хурдац тухайн орны нийгмийн бүтцийн бүрдэлт ихээхэн үүрэгтэй байдаг билээ гэтэл Хятадын шинжээчдийн үзэж байгаагаар өнөөгийн Хятадын нийгмийн бүтэц эдийн засгийн шинэчлэлийн зорилгод нийцэхгүй байгаа ажээ. Юуны өмнө их хэмжээний тариачин байгаа явдал саад болж байгаа хийгээд дунд ангийн хувь бага байгаа болно. Шинэчлэлийг хэрэгжүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд их хэмжээний дунд ангийг бүрдүүлэх шаардлагатай байдаг байна. Өнөөдөр Хятадад дунд анги нийгмийн зөвхөн 18%-ийг эзэлдэг байна. Гэтэл АНУ-д 60%-ийг эзэлдэг байх жишээтэй. Иймээс өнөөдөр Хятадын нийгэм-эдийн засгийн гол зорилт бол нийгмийн бүтцийг оновчтой бүрдүүлэх явдал ажээ.⁹

Өөр нэгэн судлаач Хятадын нийгэмд дунд анги жинхэнэ утгаараа бий болоогүй хэмээн дүгнэсэн байна. Нийгэм судлаач Хан Санзины үзэж байгаагаар өнөөгийн хятадын нийгмийн дунд анги бол маш хэврэг давхрага, учир нь тэд нийгмийн статусын хувьд хангалуун, ёс зүйн талаас олон нийтийн нүдэнд шаардлагатай зүйл мэт боловч жинхэнэ утгаараа эдийн засгийн хувьд өөрийн ангийн боломжийг хэрэгжүүлэх бололцоогүй хэмээн үзжээ.¹⁰ Цааш нь Хан Санзин нийгмийн анги давхрагатай холбоотой асуудлыг хөндөхдөө, өнөөгийн Хятад улсад дунд ангийг бүрэлдүүлэх, хүний нөөц бий болгох хийгээд түүний оновчтой зөв хуваарилалтын стратеги орхигдсоныг дурьдаад доорхи дутагдлуудыг заажээ. Үүнд: 1. Бүх түвшний албан хаагчдын ажил хэрэгч бус байдал 2. Албан тушаалын хийх систем хөгжөөгүй 3. Үндэсний төсвөөс боловсролд оруулах хувь маш доогуур. 4. Авъяастай, чадварлаг боловсон хүчнийг дэвшүүлэн гаргаж ирэхэд өнөөгийн албан тушаалын шатлалын систем саад учруулж буй явдал 5. Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх хөшүүрэг байхгүй. 6. Хүн амын амьжиргааны түвшнийг сайжруулах, нийтийн аюулгүй байдлыг хангах бодлого хангалттай хэрэгжихгүй буюу түүнд зохих анхаарал хандуулахгүй байгаа зэргийг дурьджээ.¹¹

Ер нь Хятадын нийгэм судлаач эрдэмтэд эдийн засгийн хөгжил түргэсхийн хамт эдийн засаг нийгмийн харьцааны зохих тэнцвэр алдагдаж улмаар энэ нь Хятадын нийгмийн тогтвортой байдалд нөлөөлж байна гэсэн дүгнэлт хийжээ. Тухайлбал Хятадын эрдэмтэн Цао Зывэй “The Role of Government in Chinas Social Transition” хэмээх өгүүлэлдээ хот суурин газар хийгээд хөдөө тосгоны хөгжлийн ялгаа их байгаа нь хөдөө тосгонд нийт хөрөнгө оруулалтын 4/1 ноогдож байгаагаар холбоотой гээд бүс нутгийн ялгаа нь нийгмийн тогтвортой байдалд саад болохуйц чухал хүчин зүйл хэмээжээ. Мөн хот, хөдөө

тосгон, бүс нутаг, үйлдвэр болон нийгмийн давхаргын орлогын ялгаа харилцан адилгүй байгаа гээд тухайлбал Хятадын гэр бүлийн зөвхөн 10%-д хамаарагдах хөрөнгө чинээлэг хүмүүс нийт нийгмийн баялгын 45%-ийг эзэлж байгаа болон баян ядуугийн ялгаа маш ихээр өсч байгааг дурьдсан байна. Тэрээр тэнцвэртэй хөгжлийн хамгийн шаардлагатай чухал хүчин зүйл бол төрийн зохицуулалт хэмээн тэмдэглэжээ. Хөгжлийн тэнцвэргүй байдлыг засахад төрийн үүргийг тод болгох, засгийн газрын эдийн засгийн менежментийг зохистой болгох ялангуяа нийгмийн талын менежмент өөрөөр хэлбэл нийгэм олон нийтэд үзүүлэх үйлчилгээ, зах зээлийн хяналтыг төрийн бодлогын цөм болгох ёстой хэмээн үзжээ. Чингэхдээ төр энэ бүгдийг гардан хийх биш зөвхөн чиглүүлэх үүрэгтэй. Харин төрөөс юуны түрүүнд доорхи 5 чиглэлээр санхүүгийн өөрчлөлтийг хийх хэрэгтэйг заажээ. Үүнд: Нийгмийн аюулгүй байдал, олон нийтийн эрүүл мэндийг сайжруулах /үүний шаардлага нь СААРС дэгдэж байх үед хурцаар илэрсэн/, нийтийн боловсрол, мэргэжлийн бэлтгэлийг хангах, нийгмийн тусламж, хамгааллын системийг өөрчлөх /чингэхдээ нийгмийн хамгаалал нийгмийн аюулгүй байдлаас ялгаатай гэдгийг анхаарах/, нийтийн тав тух, тухайлбал дэд бүтцээр хангах /унаа, цахилгаан, зам гүүр, харилцаа холбоо гэх мэт/ зайлшгүй шаардлагатай ажээ. Дээрхи таван чиглэлийн санхүүжилтэнд төр онцгой анхаарал хандуулах ёстой ажээ. Нөгөөтээгүүр төв засгийн газар орон нутгийн засаглалын хоорондын харилцааг зөв зохистой тодорхойлох шаардлагыг дурьдаад чингэхийн тулд өнөө мөрдөж буй татварын системийг өөрчлөн шинэчлэх, өөрөөр хэлбэл 1. Төвийн болон орон нутгийн хэмжээнд санхүү, татварын системийг оновчтой тодорхойлох. 2. Төв, бүс нутаг, муж зэргийн засаглалын эрх мэдлийн хязгааралт мөн хариуцлагын системийг оновчтой болгож татвар санхүүгийн системийг шинэчлэх. Чингэхдээ татварын системийг байнга шаардлагын дагуу өөрчилж байх 3. Орон нутгийн засаглал нь зах зээлийг хөгжүүлэхдээ орон нутгийн үзэлтэй эрс тэмцэж орон нутгийн зах зээлийг нийт үндэсний хэмжээний зах зээлтэй холбох ажлыг эрхлэн явуулах шаардлагатай ажээ. 4. Өнөөгийн мөрдөж буй систем нь нийгмийн бүхий л салбар тухайлбал эдийн засгийн үйл ажиллагаа, нийтийн эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал зэрэг нь хоорондоо уялдаа холбоогүй бие даасан байдалтай байгааг халж харилцан уялдаа холбоотой болгох шаардлагатай ажээ.

Ийнхүү Хятад дахь нийгэм-эдийн засгийн шинэтгэл ид өрнөж байгаа бөгөөд хэрэгжилтийн явцад олон бэрхшээл сорилтуудтай тулгарч байгаа болно. Эдгээр нь шинэ хуучны хоорондын зөрчил, шинэчлэлийн явцад гарах зайлшгүй хүндрэлүүд мөн зарим судлаачдын үзэж байгаагаар бодлогын алдаа ч байж болзошгүй ажээ.¹²

Нөгөөтэйгүүр нийгэм эдийн засгийн шилжилт нь урд хожид байгаагүй хосгүй зүйл бөгөөд төрийн оролцоо үүнд зайлшгүй шаардлагатайг Хятадын эрдэмтэн судлаачид тэмдэглэж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. 2005 он: Хятадын нийгмийн байдлын талаархи хөх ном. Бээжин, Шэхүй кесюэ вэньсянь чубаньшэ , 2005, т.5-10
2. Жэньмин жибао 2002.11.18
3. Жэньмин жибао 2003.3.20
4. Жэньмин жибао /2004.3.19
5. Жэньминжибао 2004.3.19, 2006.3.7
6. Лу Сюэ И Орчин үеийн Хятадын нийгмийн бүтцийн тухайд Бээжин 2002
7. О.Почагина Проблемы суицида в современном Китае- Проблемы Дальнего Востока №2, 2005 с.106
8. Нинся шэхуй кэсюэ. Иньчуань, 2000 №1. т.53-57
9. Лу Сюэ И Орчин үеийн Хятадын нийгмийн бүтэц. Бээжин 2002
10. Socio –economic Transition, Conflict and Goverment in China Beijing 2005, p.141
11. Дээрхи зохиол т.141
12. Liu Neng. Socio- economic Transition and Goverment in China- State and Civil Society in the Context of Transition. Beijing 2005. P. 143